

ШҮҮГЧ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНААС ТАТГАЛЗАН ГАРАХ ТУХАЙ



Н.НАСАНЖАРГАЛ

Өмнөговь аймгийн эрүү, иргэний хэрэг давж заалдах шатны шүүгч

NASANJARGAL N.

Judge of Criminal and Civil affairs appellate court of Umnugovi aimag

Товч агуулга: Хэрэг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй хуульд заасан үндэслэл бий болсон буюу ашиг сонирхлын зөрчил үүснэ гэж үзсэн шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарах үүргээ биелүүлж байгаа болон уг үүргээ биелүүлээгүй шүүгчийг татгалзан гаргах тухай хэргийн оролцогчийн хүсэлтийг шийдвэрлэж буй практик байдалд дүн шинжилгээ хийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлсэн.

Судалгааг Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхээс 2014 оноос 2016 оны 6 дугаар сарын 10-ны хүртэлх хугацаанд гарсан шүүгчийн захирамж, Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, холбогдох хэргүүдэд үндэслэв.

Abstract: An individual citizen has right to be restored and to be constituted the full power of right by the jurisdiction of the respective court if one's right which is under the constitution and another legal act is violated. ...every individual citizen ... in the case, and equality rights on the basis of a transparent manner and in the Universal Declaration of Human Rights "is entitled to judgment subject only to the law others affected by all the demands of justice, "...every person can have a fair trial ... right" to guarantee the basic legal sources referred to in Article 16 of the Constitution of Mongolia depends on that review process should fulfill its obligations in accordance with the procedure established by the judge.

The judge will respect the human rights and the law and follow the principle of being respectively responsible for one's compulsory activity including directing oneself into the state of neutral, independent and objective point of view in order to judge a case. The judge will refuse to judge and get involved in the case if one has a query of being under circumstances of colliding the legal act or difficulty of following responsibility of compulsory activity.

It is deliberately manifested after learning of court's practical case in the implementation of legal regulation about judge's conflict of interests and justification of withdrawal implementation of the legal regulation.

Нэг. Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах тухай өнөөгийн практик, эрх зүйн орчин:

Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй тохиолдлыг Иргэний хэрэг шүүхэд

хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид ИХШХШТХ-ийн гэх/ 91 дүгээр зүйлийн 91.1 дэх хэсэг, 84 дүгээр зүйлд нэрлэн зааж, уг нөхцөл байдал бий болсон үед энэ тухайгаа "мэдэгдэж" татгалзан гарахыг ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсгээр шүүгчид

үүрэг болгон зохицуулсан.

Энэ бол “Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй. ...Хүн бүр ... тухайн хэргийг бүрэн, тэгш эрхийн үндсэн дээр ил тод байдлаар, шударга ёсны бүх шаардлагын дагуу бусдын нөлөөнд автагдаагүй гагцхүү хуульд захирагдах шүүхээр шийдвэрлүүлэх эрхтэй”¹ гэсэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын, “...хүн бүр шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй” гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан эрх зүйн үндсэн эх сурвалжийн хэрэгжих баталгааны нэгээхэн хэсэг юм.

Шүүгч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж эс чадваас иргэний эрх зөрчигдөж шударга ёс алдагдана. Шүүхэд хандсан иргэн хүн эрх зүйт төрийн шударга шүүхээр шүүлгэсэндээ сэтгэл хангалуун байх нь хэрэг маргааныг нь шийдвэрлэсэн шүүгчийн хуулийг чанд сахиж, бие даасан байдалдаа эргэлзээ төрүүлэхгүйгээр үүргээ биелүүлэх ёс зүйгээс хамаарна.

Шүүгч энэ үүргээ хэрхэн биелүүлж байгааг Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн² практикаас судалж үзвэл 2014 онд 5, 2015 онд 8, 2016 оны 6 дугаар сарын 10-ны байдлаар 4 удаа шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах тухайгаа мэдэгдсэн


байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй үндэслэл тогтоогдвол энэ тухайгаа “мэдэгдэж” татгалзан гарах энэ үүргээ амаар эсхүл бичгээр чухам аль хэлбрээр, хэнд мэдэгдэх, мэдсэн хүн хэрхэх ёстой, татгалзан гарах үндэслэлээ нотлох шаардлагатай эсэх зэрэг нь хуульд тодорхойгүй байна.

Тухайн шүүх нь 2014 онд Шүүгчдийн зөвлөгөөнөөр “шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах тухай хүсэлтээ ерөнхий шүүгчид хандан гаргаж, Ерөнхий шүүгч хүсэлтийг хүлээн авах эсэхийг захирамж гарган шийдвэрлэдэг” байсныг өөрчилж, шүүгч татгалзан гарах тохиолдол бий болбол энэ талаарх тайлбарыг бичгээр гарган хэрэгт хавсарган, шүүгчдийн зөвлөгөөнөөс урьдчилан тогтоосон журмын³ дагуу өөр шүүгчид хэргийг шууд шилжүүлж байх журам тогтоосон байна. Энэ журмаар хэрэг хянан шийдвэрлэхээс ажиллагаанаас гарах шүүгчийн мэдэгдлийн дагуу 4 хэрэг өөр шүүгчид шилжжээ.

Шүүгч ямар нэг шийдвэргүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас өөрөө гарсан хэрэгт⁴ шүүгчийн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарах хуулийн үндэслэл бий болсон тул гарч байна” гэсэн агуулга бүхий бичиг, ИХШХШТХ-ийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэгт заасны дагуу

Шүүгчийн татгалзан гарах мэдэгдэл



¹ Хүний эрхийн түгээмэл тунхаглал.

² Шүүх байгуулах тухай хууль. 2015 оны 6 дугаар сарын 19. Өмнөговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх. Өмнө нь 2014-2015 оны 6 дугаар сарын 30 хүртэл Шүүх байгуулах тухай 2013 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн хуулиар Сум дундын 15 дугаар шүүх нэртэй байсан.

хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилсон Шүүгчдийн зөвлөлгөөний тогтоолын хуулбарын хамт авагдсан байна. Үүнээс үзэхэд шүүгч мэдэгдэх үүргээ тайлбар гаргаснаар биелүүлж, ингэснээр уг хэргийг шүүгчдийн зөвлөлгөөнөөс урьдчилан тогтоосон хуваарийн дагуу өөр шүүгч хүлээн авч хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэн явуулж байгаа мэт харагдах боловч

³ Тус шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол. 2014 оны 6 дугаар сарын 09-ны өдрийн № 22.

⁴ Сум дундын 15 дугаар шүүхийн 2015 оны 4 сарын 09-ны шийдвэр, дугаар 120, 37 дахь тал



ХҮҮЛЬ САХИУЛАХУЙ

хэний нэхэмжлэлтэй хэдэн хуудастай хэрэг, хэн гэдэг шүүгчээс хэн гэдэг шүүгчид хуваарилагдан очиж байгааг бүртгэсэн бүртгэл шүүхэд⁵ хөтлөгдөггүй тул шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарч байгаа байдлыг зөвхөн тухайн хэргийн материалыг шүүж үзэхээс өөрөөр мэдэх боломжгүй байна.

2015, 2016 оны эхний 5 сард шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарах үүргээ дараах байдлаар “хэрэгжүүлжээ”. Үүнд:

-Ерөнхий шүүгч, шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарах “хүсэлт”-ээ Ерөнхий шүүгч, Шүүгчдийн зөвлөгөөнд хандан гаргана

-Шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарах эсэхийг Ерөнхий шүүгч нь захирамжаар⁶, Ерөнхий шүүгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарах эсэхийг Шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж, тогтоолоор⁷ шийдвэрлэнэ.


-Хүсэлтийг хэрэгсэхгүй болговол ерөнхий шүүгч, шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарахгүйгээр хэргийг үргэлжлүүлэн шийдвэрлэж байна.⁸

“Болохгүй” гэх үгийн утга, агуулга нь “таарахгүй, тохирохгүй, нийцэхгүй”, “хоригтой, цээртэй үйл” гэсэн санааг илэрхийлж байна.

Үүрэг нь тодорхой үйлдэл хийхийг, тодорхой үйлдэл эс үйлдэхийг зааж хуулийн хэм хэмжээнд хэлбэржсэн байна.⁹ Тэгэхээр хэрэг хянан шийдвэрлэх

ажиллагаанд оролцож болохгүй тохиолдолд хэн нэгнээс үл хамааран шүүгч өөрөө уг ажиллагаанаас гарч, бусдад шударга шүүхээр шүүлгэх эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх ёстой. Гэтэл Ерөнхий шүүгч, Шүүгчдийн зөвлөгөөн нь шүүгчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх эсэхийг шийдэж байгаа нь шүүгч нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ бусдаас хараат бус байж, Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль, Шүүгчийн ёс зүйн дүрмийг чанд сахин биелүүлэх үүргээ биелүүлэхгүй байж болох сөрөг үр дагаварт хүргэж байна. Мөн хүсэлтийг маш богино хугацаанд шийдвэрлэдэг, тухайн шийдвэрт хэргийн оролцогчдоос гомдол гаргах эрхгүй байгаагийн зэрэгцээ шүүгчийн “татгалзан гарах” мэдэгдлийн талаар хэргийн оролцогч

2015 он



нар хэргийн материалтай танилцах үед л мэдэх бололцоотой байна.

Хүсэлтийг шийдвэрлэсэн хугацааг харуулбал:

Тиймээс шүүгч ИХШХШТХ –ийн 91 дүгээр зүйлийн 91.1.1-91.1.4-т¹⁰ зааснаар

- урьд нь уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, эвлэрүүлэн зуучлагч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчийн хувиар оролцсон,

- уг хэргийн болон шүүх хуралдааны

тал.

¹⁰ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002.

⁵ Мөн шүүхэд

⁶ Ерөнхий шүүгчийн захирамж. 2014 оны 12 дугаар сарын 12. №02, 2015 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн №47, 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн №129, 2015 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 204, 2015 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн №248, №254, 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн №143/ЕШ2015/00333, 2016 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн №143/ЕШ2016/00218.

⁷ Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол. 2015 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн № 56, 2016 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн №143/ЗТ2016/00067, 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн №143/ЗТ2016/00071, №143/ЗТ2016/00067 тоот тогтоолууд.

⁸ Ерөнхий шүүгчийн захирамж. 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн № 02.

Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол. 2016 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 143/ЗТ2016/00067.

⁹ Т.Саруул. Эрх зүй хэрэглэх арга зүй. УБ., 2014. 20 дугаар



ХҮҮЛЬ
САХИУЛАХУЙ

оролцогчийн гэр бүл, төрөл, садан бол, эсхүл шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн болон төрөл, садангийн холбоотой хүмүүс орсон байвал,

- хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, түүнчлэн уг хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал,

- ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас өөрөө татгалзан гарах үүргээ биелүүлж, хэрэг хянан шийдвэрлэх цаашдын ажиллагаанд оролцохгүй байх ёстой.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбарт ¹¹ "... Шүүх энэ ИХШХШТХ-ийн 91 дүгээр зүйлд заасан татгалзан гарах үндэслэл бий болсон тохиолдолд мөн ИХШХШТХ-ийн 92.1, 92.2-т заасны дагуу татгалзан гарах буюу татгалзан гаргах асуудлыг нэгэн адил үзэж тэдгээрийн хүсэлтийг шүүх буюу шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж ... хүсэлтийг хүлээн авах эсэхийг шүүгчийн захирамж буюу шүүхийн тогтоол гарган шийдвэрлэнэ." гэж тайлбарласан. "Гарах", "гаргах" ойлголтыг нэг ойлголт гэж үзэж ирснээс шүүгч нь өөрийн "гарах" үүргээ биелүүлэх эсэхээ Ерөнхий шүүгчээрээ шийдвэрлүүлдэг практик тогтсон байж болох юм.

Шүүхээс шүүгчийн татгалзан гарах асуудлыг шийдвэрлэсэн Ерөнхий шүүгчийн захирамжууд нь ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.6 дахь хэсгийн дагуу гарсан байгаа нь "Гарах", "гаргах" ойлголтыг адил гэж үзсэнтэй холбоотой байх. Гэхдээ угаасаа үүссэн үндэслэл, гарах үр дагавраараа хууль зүйн хоёр өөр ойлголтыг хуулинд ялгаатай байдлаар нь зохицуулж өгөөгүйгээс тухайн тохиолдол бий болсон үед хуулийг хэрэглэхэд бэрхшээлтэй байгаа нь Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоос

¹¹ Монгол Улсын Дээд шүүх, " Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар". УБ., 2007. 255 дахь тал.

Монгол Улсын Дээд шүүх. " Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар". УБ., 2014. 274 дэх тал

харагдаж байна. Тухайлбал, Шүүгчдийн зөвлөгөөний 2016 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн д/143/зт2016/00067 тоот тогтоол нь Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.6 дахь хэсгийг удирдлага болгон гарсан бол 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн д/143/зт2016/00071, /143/зт2016/00072 тоот тогтоолууд нь Шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.9-т заасныг удирдлага болгон гарсан байна.

Түүнчлэн шүүгчийн татгалзан гарах асуудлыг шийдвэрлээд гарсан Ерөнхий шүүгчийн захирамж, Шүүгчийн зөвлөгөөний тогтоолд гомдол гаргах эрхгүй¹² байгаа бол шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг хүлээн авах эсэхийг хэлэлцээд, ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.4 дэх хэсэгт заасны дагуу гарсан тогтоол буюу захирамжид ИХШХШТХ-ийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт зааснаар гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гарч байгаа нь энэ асуудал "нэгэн адил" асуудал биш болохыг харуулж байна.

Шүүгчийг хуульд зааснаас өөр үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гарах, гаргахыг хориглосон тул гагцхүү аль үндэслэлээр гарах болсон нь тодорхой байхаас гадна "хэрэг" гэдэг чухамдаа хэн нэгэн хүмүүсийн хоорондоо сайн дураар өгч авалцдаг эд зүйлс биш тул ИХШХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан бичгээр баримтжуулна гэсний дагуу уг хэргийг шилжүүлэн авсан шүүгч, шүүх бүрэлдэхүүн мөн тодорхой байх ёстой.

Иймээс шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй үндэслэл бий болохыг мэдмэгц үүргээ хэрэгжүүлэх эсэхээ шийдвэрлүүлэхээр бус, харин татгалзан гарч буй үндэслэлээ

¹² Тус шүүхийн шүүгчийг татгалзан гарах асуудлыг хэлэлцээд гарсан бүх захирмж, тогтоолууд. ⁴⁵

тодорхой дурьдан, хэргийг шийдвэрлэх өөр шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилсон Шүүгчдийн зөвлөгөөний урьдчилан тогтоосон шийдвэрийг албажуулж, хэргийг шилжүүлж өгөхийг хүссэн тайлбарыг Ерөнхий шүүгч, Шүүгчдийн зөвлөгөөндөө өгөх нь зохистой.

Хоёр. Шүүгчийг татгалзан гаргах тухай гаргасан хэргийн оролцогчийн хүсэлтийг шийдвэрлэх хуулийн зохицуулалт, түүний хэрэгжиж буй байдал:

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүргээ шүүгч биелүүлээгүйгээс ашиг сонирхлын зөрчил үүссэн, хууль ёсны ашиг, сонирхол зөрчигдсөн гэж үзсэн зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч нараас тухайн шүүгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах хүсэлтийг гаргах эрхтэй.

ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.5 дахь хэсэгт “шүүгчийг татгалзан гаргах тухай асуудлыг үндэслэлтэй эсэхийг түүнийг байлцуулахгүйгээр шүүх бүрэлдэхүүний бусад шүүгчид шийдвэрлэнэ. Санал тэнцвэл шүүгчийг татгалзан гаргасанд тооцно.” гэж заасан.

ИХШХШТХ-ийндээрхзохицуулалтаас гурван шүүгчийн нэгийг татгалзан гаргахад нөгөө хоёр шүүгч шийдвэрлэх боломжтой болох нь харагдаж байна. Харин нэг шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг оролцогч нараас гаргаж, нэг шүүгч нь өөрөө татгалзан гарахаа мэдэгдсэн тохиолдолд татгалзан гарах хүсэлтээ мэдэгдсэн шүүгч нь нөгөө шүүгчийг татгалзан гаргах тухай хэргийн оролцогчийн хүсэлтийг шийдвэрлэхэд оролцох боломжгүй нь тодорхой. Иймээс шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг үлдсэн нэг шүүгч шийдвэрлэж шүүгчийн захирамж гаргах уу гэх асуудал тулгарч байна.

Нөгөө талаар хоёр шүүгчийн гаргасан шүүхийн тогтоолыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам ноцтой

зөрчиж, хууль бус бүрэлдэхүүнтэй хэргийг шийдвэрлэсэн шийдвэр гэж үзэх хууль зүйн үндэслэлтэй юм. Учир нь **Монгол Улсын Үндсэн хуулийн тавин хоёр дугаар зүйлийн 1** дэх хэсэгт “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасан. Хамтын гэсэн үгийн утгаас хоёр буюу түүнээс дээш шүүгч оролцож хэргийг шийдвэрлэх боломжтой ч ИХШХШТХ-ийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт анхан шатны журмаар шүүгч дангаар хянан шийдвэрлэхээс бусад хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй, ИХШХШТХ-ийн 166 дугаар зүйлийн 166.1 дэх хэсэгт давж заалдах журмаар хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр, ИХШХШТХ-ийн 176 дугаар зүйлийн 176.1 дэх хэсэгт хяналтын журмаар хэргийг Монгол Улсын Дээд шүүхийн 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ шүүгчийн тоог хуулиар тодорхойлжээ. Иймээс хуульд заасан тооны шүүгч оролцож хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахыг шүүх бүрэлдэхүүнтэй ажиллагаа явуулсан гэж үзэх бөгөөд хамтын зарчмаар гаргасан шийдвэр нь шүүхийн тогтоол нэртэй байх нь гэсэн томъёолол харагдаж байна.

Монгол Улсын Дээд шүүхийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”¹³ 2002 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 263 дугаар тогтоолд “...хууль бус бүрэлдэхүүнтэй хэргийг хянан шийдвэрлэсэн гэдэгт ... хамтын журмаар шийдвэрлэх хэргийг ... бүрэн бус бүрэлдэхүүнээр...хэлэлцсэнийг ойлгоно.” гэж тайлбарласан. Тэгэхээр ИХШХШТХ-ийн “бусад шүүгчид татгалзлыг шийдвэрлэнэ” гэсэн нь үлдсэн хоёр шүүгч нь шүүхийн тогтоол гарган асуудлыг шийдвэрлэнэ гэсэн санааг илэрхийлж байх тул уг тайлбраар энэ тогтоол нь “бүрэн бус бүрэлдэхүүн”-ээр гарсан хууль бус тогтоол болох нь тодорхой байна.

Эндээс хэргийг шүүгч дангаар

¹³ Монгол Улсын Дээд шүүх. “Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл”. УБ., 20.... дэх тал



МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ЁС
ЗҮЙН ДҮРЭМ

шийдвэрлэх үед татгалзан гарах хүсэлт гаргах нь харьцангуй амархан, шүүх хуралдааны өмнөх шатанд шүүгч хүсэлт гаргаснаар, харин шүүх хуралдааны үед шүүгч захирамж гарган шүүх хуралдааныг хойшлуулснаар татгалзан гарна. Энэ нь ч аргагүй, яагаад гэвэл ганцаараа байгаа учраас үг дуугүй орхиод гарахгүй нь ойлгомжтой, мөн шүүх хуралдаан эхэлсэн байгаа тул хуралдааныг хойшлуулахаас өөр аргагүй, тэгээд ч шүүх хуралдааныг хойшлуулахад шүүгч захирамж, шүүх тогтоол гаргах хуулийн заалттай учраас. Шүүх бүрэлдэхүүнтэй хэрэг, маргааныг шийдвэрлэж байгаа үед хоёр шүүгч тогтоол гаргаад байгаагийн учир нь:

- хүсэлтийг шийдвэрлэж болох хоёр шүүгч байгаа,

- нөгөөтэйгүүр хэрэг биш хүсэлт шийдвэрлэж байгаа гэсэн хэвшмэл ойлголт тогтсонтой,

- татгалзлыг шийдвэрлэх эрхийг зөвхөн тэдэнд хуулиар олгосон, өөр шийдвэрлэх этгээдийг хуульчлаагүйтай холбоотой байж болох юм.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Шүүхийн ёс зүйн дүрэмд “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүгчийн өөр бусад ажлаас ямагт илүү чухал гэдгийг ухамсарлаж, түүний эрхлэх бусад үйл ажиллагаа, хувийн амьдрал нь мэргэжлийн үүрэгтэй нь зөрчилдөх нөхцөл байдал бий болгохоос зайлсхийнэ”¹⁴ гэсний шүүгч нь тухайн маргааныг үнэн зөв шийдвэрлэхээс хамаарахгүйгээр шүүхийн тогтоосон журмыг баримтлах үүрэгтэй.

Ашиг сонирхлын зөрчилтэй тулгарсан шүүгчийг татгалзан гарах, гаргах хүсэлтийг шийдвэрлэх талаар хуулиар тогтоосон журмыг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй асуудал байгаа тул эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүнд:

- 1.Шүүгч өөрөө татгалзаж гарах, үүргээ биелүүлэх эсэхийг Ерөнхий шүүгч, Шүүгчдийн зөвлөгөөн шийдвэрлэж, уг шийдвэрт гомдол гаргах эрхийг хэргийн оролцогчдод олгохгүй байгаа нь Үндсэн хуулиар баталгаажсан “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй...”, “... шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...”-ийг хязгаарлаж, нөгөө талаар шүүгчийн хараат бус байдалд Ерөнхий шүүгч, Шүүгчдийн зөвлөгөөн нөлөөлж байна бодож байна. Иймээс татгалзан гарах асуудлын талаар хуульд нарийвчилсан зохицуулалтыг оруулах шаардлагатай;

- 2.Хэргийг шүүх бүрэлдэхүүнтэй хэлэлцэх явцад шүүгчийг татгалзах, шүүгч гарах тохиолдол үүсвэл шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдаанаа хойшлуулж шүүхийн тогтоол гаргаад, татгалзлыг өөр этгээдэд шийдвэрлүүлэх тухай өөрчлөлтийг ИХШХШТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.5-д оруулах;

- 3.Татгалзан гаргах хүсэлт гарч буй нь шүүхээр хэргээ шудрагаар шийдвэрлүүлэх эрхээ эдлэх боломжгүй боллоо гэсэн хэргийн оролцогчийн хүсэлт, нөгөө талаас татгалзагдаж буй шүүгчийн хувьд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байж болох ноцтой асуудалтай тулгарч байна гэсэн үг. Татгалзан гарах хүсэлтийг шийдвэрлэх нь тэдний аль алиных нь эрхийн хамгаалалт болох учир асуудалд хөнгөн хандаж болохгүй тул татгалзан гарах хүсэлтийг шийдвэрлэх хугацааг хуулинд тодорхой тусгах шаардлагатай;

- 4.ИХШХШТХ-ийн 80 дугаар зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлэх үндэслэлийг нэрлэн зааж, түүнээс өөр үндэслэлээр хэрэг шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлэхийг хориглоно гэж заасан. Иймээс шүүгчийн татгалзан гарах, татгалзан гаргах хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх хугацааг түдгэлзүүлэх зохицуулалтыг хуулинд оруулах;

- 5.Нийтийн албанд нийтийн болон

¹⁴ “Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэм”. 2014. 3.1 дүгээр зүйл.



хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн¹⁵ 3 дугаар зүйлийн 3.1.11-т “ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж тухайн нийтийн албан тушаалтан өөрийн нэг ангид сурч байсан болон сурч байгаа этгээд, мөн гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд, нэг нутгийн хүн гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг ойлгоно гэж тайлбарласан.

Гэвч “Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” мөн эсэхэд эргэлзээтэй нөхцөл байдал шүүгчид, хэргийн оролцогчид, шийдвэрлэх эрх бүхий этгээдэд үүсэж болох юм. Жишээ нь шүүгчийн хэргийн оролцогч нь гэр бүлийн хүнтэй үеэл хүүхдүүд байна гэж татгалзан гарах тухай хүсэлт гаргасныг хэрэгсэхгүй болгосон байна.¹⁶ Иймээс татгалзан гарах хүсэлтийг шийдвэрлэх хугацаанд татгалзан гарах, гаргах үндэслэлээ гэрчийн мэдүүлэг, бусад нотлох баримтаар нотлох боломжийг татгалзагдаж буй, татгалзаж буй этгээдүүдэд олгох, татгалзлыг шийдвэрлэх этгээд, шийдвэрт гомдол гаргах зэрэг асуудлыг тодорхой зохицуулсан заалтыг хуулинд оруулах зэрэг болно.

**Уншиж танилцан нийтлэхийг
зөвшөөрсөн, Сэтгүүлийн зөвлөлийн
гишүүн, хууль зүйн доктор,
цагдаагийн хошууч Б.Энхболд**

¹⁵ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 2012.

¹⁶ Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол. 2016 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн №143/ЗТ2016/00067